

Арав. Хавсралт

Хавсралт 1.

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР:

1. Хүүхэд: 18 нас хүртэлх хүн³
2. Хүүхэд хамгаалал⁴: Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.
3. Хүүхдэд ээлтэй байгууллага: Бие махбод, сэтгэл санааны, бэлгийн болон үл хайхрах хүчирхийллээс (байдлаас) хүүхдийг хамгаалах үзэл санаа, үйл ажиллагааг өөрийн байгууллагын бүх түвшинд нэвтрүүлсэн, дадал болгосон, дотоод журамдаа тусгасан, байгууллагын соёлд нэвт шингээсэн байгууллага.
4. Хүүхэд хамгааллын бодлого: Хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд байгууллага бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичиг. Үүнд хүүхэд бүрд аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг тусгасан байна.
5. “Эцэг эхийн зөвлөл”⁵ гэж хүүхдийн сурч боловсрох, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, соён гэгээрүүлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгоход дэмжих, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд хөндлөнгийн хяналт тавих, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх үүднээс тухайн байгууллагаас эрх үүрэг хүлээж албан ёсоор томилогдсон хамт олны төлөөллөөс бүрдсэн зөвлөлийг хэлнэ.
6. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд⁶: Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд.
7. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл⁷: Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие мах бодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ. Хүчирхийллийн хэлбэр:
 - бие мах бодын хүчирхийлэл
 - сэтгэл санааны хүчирхийлэл
 - бэлгийн хүчирхийлэл
 - үл хайхрах
8. Бие мах бодийн хүчирхийлэл: Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах, давамгайл байдал тогтоох, шийтгэх зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед халдсаныг эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ.
9. Үл хайхрах: Зохистой хоол унд, хувцас, орон байр, эмнэлгийн тусламж боловсрол эзэмших зэрэг хүүхдийн үндсэн хэрэгцээг хангаж чадахгүй байхыг хэлнэ.

³ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 1 дүгээр зүйл

⁴ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт

⁵ Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
Эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмжийн 2.1 дэх заалт

⁶ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх аалт

⁷ Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 1 дүгээр зүйлийн 4.1.8 дэх заалт

10. Сэтгэл санааны хүчирхийлэл: Асран хамгаалагчийн зүгээс хүүхдийг үнэ цэнгүй, согогтой, чамд хэн ч хайргүй, чамтай хамт байхыг хэн ч хүсэхгүй гэж ойлгуулах, айлган сүрдүүлэх, хэл амаар доромжлох, загнах, гутаах зэрэг үйлдэл юм.
11. Бэлгийн хүчирхийлэл: Хүүхдийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан, энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ.
12. Хүүхдийг садар самуунд ашиглах⁸: Бэлгийн амьдралыг харуулан дүрслэн бичсэн бичлэг, видео бичлэг, зураг бүтээхдээ хүүхдийг оролцуулах үйлдэл
13. Мөлжлөг: Хүүхдийн эмзэг байдлыг ашиглан тэднийг хүнд хөдөлмөр эрхлүүлэх, садар самуун болон бусад эрсдэлт үйл ажиллагаанд уруу татан ашиг олох үйлдэл
14. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ⁹: Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа
15. "Соёлын үнэт зүйл"¹⁰ гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, эсхүл хүний оюун санаа, үйлдэхүйн үр дүнд бий болсон соёлын агуулга бүхий биет болон биет бус илэрхийллийг;
16. "Соёлын боловсрол"¹¹: Хүнийг соён гэгээрүүлэх, авьяас, ур чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, үндэсний соёлын үнэт зүйлийг эрхэмлэн дээдлэх, хүндэтгэх, хамгаалах дадал, чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.
17. "Соёлын байгууллага"¹² гэж энэ хуульд заасан журмын дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;
18. "Соёлын ажилтан"¹³ гэж соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хамт олон, бүлэг хүнийг;
19. "Соёлын бүтээгдэхүүн"¹⁴ гэж соёлын үнэт зүйл, түүнтэй холбоотой үйлчилгээг агуулсан, эдийн засгийн нэмүү өртөг шингэсэн биет болон биет бус зүйлийг;
20. "Соёлын үйлчилгээ"¹⁵ гэж арилжааны үнэ цэнээс үл хамааран, хүний соёлын хэрэгцээг хангах зорилгоор үзүүлж байгаа соёлын илэрхийллийг агуулсан үйлчилгээг;
21. "Соёлын бүтээлч үйлдвэрлэл"¹⁶ гэж хүний бүтээлч сэтгэлгээ, авьяас билэг, ур чадварын үр дүнд техник технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох үйл явцыг;

⁸ Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг

⁹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт

¹⁰ Соёлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт

¹¹ Соёлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг

¹² Соёлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт

¹³ Соёлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт

¹⁴ Соёлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт

¹⁵ Соёлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт

Хавсралт 2.

**ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР СОЁЛЫН САЛБАРТ МӨРДӨГДӨХ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ, СТАНДАРТ,
ТОГТООЛ ШИЙДВЭР, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ:**

Олон улсын гэрээ, конвенц:

- ✓ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 17 дугаар зүйлийн с, d заалт, 23 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн с, d, e заалт, 31 дүгээр зүйл;
- ✓ НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар зөвлөмжийн 39 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн b заалт,

Хууль:

- ✓ Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёр дугаар бүлэг;
- ✓ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6, 7, 10 дугаар зүйл;
- ✓ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйл, 9, 9¹ дүгээр зүйл;
- ✓ Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.2.3 дахь заалт;
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16, 28, 29 дүгээр зүйл;
- ✓ Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг;
- ✓ Соёлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 8 дугаар зүйлийн 8.4, 8.6 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг;
- ✓ Кино урлагийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт;
- ✓ Музейн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг;
- ✓ Номын сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2 дахь заалт, 15 дугаар зүйл;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 39 дүгээр зүйл;
- ✓ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 27 дугаар зүйл;
- ✓ Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйл;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2, 28.5 дахь хэсэг, 35 дугаар зүйл;

10.2.3. Тогтоол, шийдвэр, албан даалгавар:

- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн “Хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах тухай” 01 албан даалгавар;

- ✓ Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоол;
- ✓ Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01 тоот тогтоол;
- ✓ Монгол Улсын Соёлын сайдын 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн “Салбарын хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар

Дүрэм, журам, стандарт:

- ✓ Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио телевизийн хөтөлбөрийн дүрэм”;
- ✓ Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага” MNS 6587:2016 стандарт;
- ✓ Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742: 2019;
- ✓ Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5634:2006;
- ✓ Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны стандарт MNS 6476: 2014;
- ✓ Соёлын төв, соёлын ордон. Орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 6981 : 2022
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан “Угийн бичиг хөтлөх журам”;
- ✓ Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам

Бодлогын баримт бичиг:

- ✓ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”;
- ✓ Монгол Улсын Засгийн Газрын тогтоол 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”.

Хавсралт.3

**Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг
хүлээн зөвшөөрөх тухай**

20 .. оны .. дугаар сарын өдөр

Дугаар:

..... овогтой би

энэхүү байгууллагын Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг уншиж танилцлаа.

Миний бие энд дурдсан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгагдсан бүх зарчмуудыг хүлээн зөвшөөрч энэ байгууллагад ажиллаж байх хугацаандаа хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллах болно.

.....
(Овог нэр)

.....
(Албан тушаал)

.....
(Гарын үсэг)

Хавсралт 4.

**СОЁЛЫН САЛБАРЫН ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ**

1. Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого нь Монгол Улсад соёлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллага, ажилтанд хамаарна.

2. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын “43.3-т “Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ” гэх заалтын дагуу хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөж ажиллана.

3. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолд заасны дагуу байгууллага бүр дэргэдээ “Эцэг эхийн зөвлөл” байгуулах ба зөвлөл нь бүтэц, чиглэл, үйл ажиллагаандаа тус тогтоолын 2 дугаар хавсралтад заасан байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмжийг мөрдлөг болгохыг зөвлөж байна.

4. Соёлын байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх өөрийн байгууллагын удирдах албан тушаалтан, ажилтны төлөөллөөс бүрдсэн /3-9 гишүүнтэй/ “Эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулж ажиллах ба зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тайлагнах;
- хүүхэд хамгааллын бодлогыг мөрдлөг болгож, харагдахуйц газар байршуулах, сурталчлан таниулах;
- хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцааны чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;
- байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлж, судалгаанд үндэслэн гэр бүл, хүүхэд рүү чиглэсэн гэр бүлийн боловсрол олгох, хүүхдийн хөгжлийг дэмжих;
- байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнээр хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих талаар удирдлагатай хамтран ажиллах;
- хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан тохиолдолд хүүхдийн тусламжийн утас 108, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага, цагдаагийн байгууллагад холбон зуучлах, мэдээлэх арга хэмжээ авч ажиллана.

5. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон тухайн орон нутгийн Соёл, урлагийн газраас хүүхэд хамгааллын бодлого болон хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа, соёлын боловсролын чиглэлээрх арга зүйн зөвлөгөө, сургалт, мэдээллийг авч болно.

6. Хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийлэл, дарамт, гэмт хэргийн сэжиг таамаг илэрсэн тохиолдолд хүүхдийн тусламжийн утас 108, цагдаагийн байгууллага 102 тоот утсанд мэдээлэл өгөх эсвэл харьяа нутаг дэвсгэрийн хамтарсан багт мэдээлж хамтран ажиллахыг зөвлөж байна.

Соёлын сайдын 2022 оны 19 дугаар
сарын 23-ны өдрийн 2/424 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

СОЁЛЫН САЛБАРЫН АЛБАН ХААГЧИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь соёлын салбарын байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч /цаашид соёлын байгууллагын албан хаагч гэх/ бүр ажлын байр, гэр бүл, нийгмийн бүхий л орчинд хүүхэд хамгааллын хувьд эрсдэлтэй, зохисгүй зан үйл гаргахгүй байхад анхаарч, хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг тогтоож, мөрдөн хэвшүүлэх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Ёс зүйн дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн соёлын байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч бүр дагаж мөрдөнө.
- 1.3. Соёлын байгууллагын удирдах албан тушаалтан хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, албан хаагч энэ дүрмээр хүлээсэн хэм хэмжээг сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Хоёр. Соёлын байгууллагын албан хаагчийн хүүхэд хамгааллын

ёс зүйн хэм хэмжээ

2.1. Соёлын байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч нь үйл ажиллагаандаа болон гэр бүл, нийгмийн орчинд дор дурдсан хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө:

2.1.1. үзэл бодол, зан суртахуун, үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хүүхдийн эрх, хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина;

2.1.2. хүүхдийн нэр хүнд, язгуур эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэнэ;

2.1.3. хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг эрхэмлэж, хүчирхийллийг үл тэвчих хандлагатай байна;

2.1.4. төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлүүлнэ;

2.1.5. хүүхэд аливаа хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдалд өртөх эрсдэлийн талаар ойлголт мэдлэгтэй байж, эрсдэлийн хүчин зүйлийг бууруулах түүнээс хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг авна;

**Гурав. Соёлын байгууллагын албан хаагчид тавих хүүхэд
хамгааллын ёс зүйн шаардлага**

3.1. Соёлын байгууллагын албан хаагч нь байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, үйлчилгээ үзүүлэхдээ болон гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийн эрхийг хангах чиглэлээр дор дурдсан ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй:

3.1.1. хүүхэд, гэр бүлийн эсрэг бүх төрлийн хүчирхийл үйлдэхээс сэргийлэх;

3.1.2. хүүхэдтэй нас, хүйс, нийгмийн гарал, амьдарч буй газар нутаг, нийгэм эдийн засгийн байдал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээлээс нь хамаарч ялгаварлан харилцах үйлдэл гаргуулахгүй байх;

3.1.3. хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэхээс сэргийлэх;

3.1.4. хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэхээс сэргийлэх;

3.1.5. хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох, хүүхдийг садар самуунд уруу татах /бэлгийн дур сонирхол төрүүлэхүйц байдал гаргах, зохисгүй хувцаслах, садар самуунд уруу татсан тоглоом тоглох/, биеийг үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэл үйлдэл гаргуулахгүй байх, сэргийлэх

3.1.6. хүүхдийн дэргэд хараал хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх, шалиг үг ярихгүй байх;

3.1.7. ажлын байр, хүүхдийн орчинд архи, тамхи, мансууруулах эм, бодис хэрэглэх; хүүхдийг хорт зуршилд уруу татахгүй байх;

3.1.8. хүүхдийн зураг, дүрс, мэдээллийг зөвшөөрөлгүй хувийн цахим хуудас, бусад нийгмийн сүлжээн дээр тавихгүй байх;

3.1.9. эцэг эхээс нь далдуур цахим болон бусад орчинд хүүхэдтэй харилцахгүй байх;

3.1.10. шөнийн цагаар эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг авч явахгүй байх;

3.1.11. хүүхэд хүчирхийлэлд өртсөн, аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд холбогдох байгууллага /Хүүхдийн тусламжийн утас-108, харьяалагдах нутаг дэвсгэр дэх гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, хамтарсан багт/, хүмүүст мэдээлэх;

3.1.12. хүүхэд хамгааллын ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх.

**Дөрөв. Хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд
хүлээлгэх хариуцлага**

4.1. Соёлын байгууллагын албан хаагчийн хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчил гэнэ.

4.2. Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан ёс зүйн дараах хариуцлага хүлээлгэнэ:

4.2.1. сануулах;

4.2.2. хуульд заасан бусад арга хэмжээ авах;

4.3. Соёлын байгууллагын албан хаагч энэ дүрмийн 3.1.12-д заасны дагуу сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөх нь ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.

4.4. Соёлын байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

**Тав. Ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээж авах,
шалгаж шийдвэрлэх**

5.1. Соёлын байгууллагын албан хаагч хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримт нь шалгалт явуулах үндэслэл болно.

5.2. Тухайн албан хаагчийн дээд шатны албан тушаалтан, байгууллагад дотоод хяналт, шалгалт хариуцсан нэгж, албан тушаалтан ажилладаг бол тэрхүү нэгж, албан тушаалтан, эсхүл байгууллагын эцэг эхийн зөвлөл мэдээллийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор шалгаж шийдвэрлэнэ.

-----oOo-----